

Аргачлалын тайлбар :

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Төсвийн орлого, зарлагын тооцоог Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсөвт (аймгийн) төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүнсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдхүүн, ноос, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

2006 оноос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 194 нэр төрөл болгож 2005 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаар нь ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт (1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох)- ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог тухайн үед амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба

түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

ХАА-Н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс : Завхан, Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс : Бөхмөрөн, Давст, Сагил, Түргэн

Зүүн бүс : Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөт бүс : Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс: Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
D - дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор оны эхний 3 сард аймгийн төсөвт 855.8 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 121.8 хувиар биелүүллээ.

Улсын төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 1119.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 1318.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 199.4 сая төгрөгөөр буюу 17.8 хувиар давуулан биелүүллээ.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 853.2 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 899.3 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 105.4 хувиар буюу 46.1 сая төгрөгөөр давууллаа. Аймгийн төсөвт 419.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 157.6 хувиар биелүүлж 153.3 сая төгрөгөөр давуулсан байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн нийт төсвийн орлого 38.9 хувиар буюу 369.5 сая төгрөгөөр илүү, үүнээс аймагт төвлөрүүлсэн орлого 4.1 хувиар буюу 16.4 сая төгрөгөөр, улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлого 64.6 хувиар буюу 353.0 сая төгрөгөөр илүү байна.

2010 оны эхний 3 сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогууднэр төрлөөрөө бүрэн биелэгдсэн байна.

Оны эхний 3 сард аймагт төвлөрүүлэх орлогын

төлөвлөгөөнөөс хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлогын төлөвлөгөө 51.1, орлого тодорхойлох боломжгүй иргэний орлогын төлөвлөгөө 28.6, авто өөрөө явагч хэрэгслэлийн татвар 47.1, бууны татвар 46.3, газрын төлбөр 30.9, улсын тэмдэгтийн хураамжийн төлөвлөгөө 4.8, хайгуулын болон ашиглалтын лицензийн төлбөр 5.6 хувиар тус тус тасарч байна.

Өнгөрсөн оны мөн үеэс хувиараа аж ахуй эрхлэгч иргэний орлого 26.1, мал бүхий иргэний орлого 42.9, улсын тэмдэгтийн хураамж 37.2, ашигт малтмалын нөөцийн төлбөр 32.3, рашаан ус ашигласны төлбөр 33.3, татварын бус орлого 40.7 хувиар тус тус бага байна.



Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 18.2 пунктээс буурч, орлогын албан татварын эзлэх хувь 14.9 пунктээр өссөн байна.

Аймгийн төсвийн зарлагад орлогын эзлэх хувь 20.7 хувь болсон нь сүүлийн 5 жилийн дунджаас 8.0 пунктээр илүү байна.



2005 оны 3 дугаар сарыг суурь болгон авч жил бүрийн 3 дугаар сарын эцэстэй харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн төсвийн орлого сүүлийн 2 жилд 2005 оны

мөн үеэс 3.5 – 4.8 дахин өсч, энэ хугацаанд төсвийн зарлага 3.1 – 3.3 дахин өссөн байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2005 I-III = 100 %

	2005 I-III	2006 I-III	2007 I-III	2008 I-III	2009 I-III	2010 I-III
Орлого	100.0	89.7	132.3	226.6	347.1	482.2
Зарлага	100.0	118.7	171.8	279.3	313.0	332.7

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА


Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 6.4 тэрбум төгрөгийг урсгал зардалд зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 6.3 хувиар илүү байна.

Нийт зарлагын 57.7 хувийг цалин хөлсөнд, 6.0 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 30.6 хувийг бусад зардалд, 5.2 хувийг урсгал шилжүүлэгт, 0.6 хувийг хөрөнгө оруулалтанд зориулан зарцуулаа.


Өнгөрсөн оны мөн үеэс цалингийн зардлын эзлэх хувь 2.4 пунктээр, НДШ-ийн зардлын эзлэх хувь 0.2 пунктээр буурч, бусад зардлын болон урсгал шилжүүлэг, хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь 0.3-1.5 пунктээр өссөн байна.

Төсвийн зардлын 19.9 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 54.5 хувийг боловсрол, 20.1 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.9 хувийг нийгмийн даатгал, халамжийн үйл ажиллагаанд, 0.7 хувийг ХАА-н салбарт, 1.8 хувийг ус цаг уур, байгаль орчны үйл ажиллагаанд зориулан зарцуулаа.

2010 оны эхний 3 сар, хувиар



2009 оны эхний 3 сар, хувиар



Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардын эзлэх хувь 2.9 пунктээр өсч, эрүүл мэндийн салбарынх 0.1 пунктээр, боловсролын салбарынх 2.6 пунктээр тус тус буурсан байна.


Төсөвт 178 байгууллагуудад 4.4 мянган хүн ажиллаж, ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 6.3 хувиар өссөн байна.

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Аймгийн төсөв 2010 оны 3 дугаар сард 338.7 сая төгрөгийн өртэй, 87.0 сая төгрөгийн

авлагатай, өнгөрсөн оны мөн үеэс өглөг 307.2 сая төгрөгөөр буюу 10.7 дахин, авлага 49.7 сая төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн байна.

3 дугаар сард 196.7 сая төгрөгийн өр шинээр үүсч, сарын эцэст 57.4 сая төгрөгийн цалингийн, 6.3 сая төгрөгийн НДШ –ийн, 16.6 сая төгрөгийн гэрэл, цахилгааны, 156.4 сая төгрөгийн түлш, халаалтын, 34.0 сая төгрөгийн цэвэр, бохир усны, 25.4 сая төгрөгийн тээвэр шатахууны, 0.9 сая төгрөгийн шуудан холбооны, 3.3 сая төгрөгийн томилолтын, 1.8 сая төгрөгийн хоолны, 16.7 сая төгрөгийн эмийн, 6.5 сая төгрөгийн байрны түрээсийн, 1.3 сая төгрөгийн урсгал засварын, 12.1 сая төгрөгийн бусад зардлын өртэй гарсан байна.



2010 оны 3 дугаар сарын эцэст байгаа өглөг, авлагын хэмжээг сүүлийн 4 жилийн дундажтай харьцуулахад өглөг 10.8 дахин буюу 307.2 сая төгрөгөөр, авлага 3.3 дахин буюу 60.7 сая төгрөгөөр өссөн байна

Хэрэглээний үнийн индекс

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 194 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож

байдаг. Энэ оны 3 -р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф 2009 оны 12 сараас 8.2, 2005 оны 12 сараас 82.9, 2009 оны 3 сараас 10.9, өмнөх сараасаа 2.2 хувиар өссөн байна.


Өмнөх 2-р сараас хүнсний барааны бүлгийн үнэ 3.8, хувцас бөс бараа гутлын бүлгийн үнэ 2.2, тээврийн бүлгийн үнэ 1.6 хувь өсч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа. Хүнсний барааны бүлэг дотроос мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 18.7, жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 28.9, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 26.2 хувь өссөн байна.

Гол нэрийн барааны өсөлтийн хувь

	ӨОМҮГ-с		өмнөх сараас
цагаан будаа	27	0	0
хонины мах	20	20	0
хиам	-11	0	0
сүү	33	0	0
үзэм	25	0	0
төмс	60	33	0
сонгино	67	0	0
элсэн чихэр	50	0	0
цайны жигнэмэг	17	0	0
тараг	50	0	0
алим	33	33	0
мандарин	9	25	0
лууван	60	33	0
манжин	60	33	0
байцаа	0	25	0
	2010.03/	2010.03/	2010.03/
	2005.12	2009.03	2009.12
	2010.02		
ЕРӨНХИЙ ИНДЕКС	182.9	110.9	108.2
			102.2

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийг тооцож үзвэл :

Хүнсний бараа, ундаа ус 13.3 %	Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ 13.3 хувь өссөн нь сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 30.3 %, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 48.3 %, жимсжигсгэний дэд бүлгийн үнэ 30.7 %, сахарын дэд бүлгийн үнэ 7.6 хувь өссөнтэй холбоотой байна
Согтууруулах ундаа, тамхи 3.1 %	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 0.4, тамхины бүлгийн үнэ 10.3 % өссөнтэй холбоотой байна
Хувцас гутал бөс 20.3 %	Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 20.3 хувь өссөн нь хөвөн бөс барааны бүлгийн үнэ 17.9, бус тэрийн хувцасны дэд бүлгийн үнэ 22.5 % үүнээс аргаттай балон хувцасны дэд бүлгийн үнэ 18.4 %, эмэгтэй балон хувцасны дэд бүлгийн үнэ 16.5 %, хүүхдийн балон хувцасны дэд бүлгийн үнэ 38.4, жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 30.2, гутлын дэд бүлгийн үнэ 17.4 хувь өссөнтэй холбоотой байна
Орон сууц, ус цахилгаан түлш 5.1 %	Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувь өссөн нь орон сууцны засвар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 6.0, усан хангамжийн дэд бүлгийн үнэ 3.3, цахилгаан болон хийн түлшний дэд бүлгийн үнэ 4.6 хувь өссөнтэй холбоотой байна
Гэр ахуйн бараа, тавилга 10.3 %	Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 10.3 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 14.8 %, цахилгаан барааны бүлгийн үнэ 17.3 %, гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны бүлгийн үнэ 28.0 %, оёмол, хамал, далазгийн үнэ 3.0 % өссөнтэй холбоотой байна
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 % буурсан нь эм тарианы дэд бүлгийн үнэ 4.6 % буурсантай холбоотой байна.	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 % буурсан нь эм тарианы дэд бүлгийн үнэ 4.6 % буурсантай холбоотой байна.
Тээвэр 4.1 %	Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 % буурсан нь хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний дэд бүлгийн үнэ 6.4 %, тээврийн үйлчилгээний дэд бүлгийн үнэ 4.2 хувь буурсантай холбоотой байна
Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 7.3 %	Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 7.3 % өссөн нь дуус гарал зургийн мэдээллийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 18.7 %, чөлөөт цаг соёлын үйлчилгээний дэд бүлгийн үнэ 1.5 % өссөнтэй холбоотой байна.
Боловсролын үйлчилгээ 20.7 %	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 20.7 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 20.7 хувиар өссөнтэй холбоотой байна.
3Ө нийтийн хоол, доуур байрны үйлчилгээ 7.4 %	Өндөг, буудал, нийтийн хоол, доуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.4 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 9.1 хувь өссөнтэй холбоотой байна.
Бусад бараа үйлчилгээ 4.8 %	Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.8 % өссөн нь хувь хүнд хандсан үйлчилгээ 8.2 % өссөнтэй холбоотой байна.



3-р сарын байдлаар 2.2 хувийн инфляцтай байгаа нь 2006, 2007, 2009 онуудынхаас 3.7 дахин их байгаа бөгөөд харин 2008 оныхоос 1.1 пунктээр бага байна.





1-р сард 2.1 хувийн, 2-р сард 3.7 хувийн, 3-р сард 2.2 хувийн инфляцтай байж, 3-р сард 2 –р сараасаа 1.5 пунктээр багассан байна.

2010 оны 3 – р сарын 31-ний байдлаар Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 2 дугаар сарын дундаж үнэтэй харьцуулахад 8.0 хувь өссөн байна.

Махны дундаж үнэ : 2010 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар хонины махны үнэ 2-р сарын дундаж үнээс 15.0 хувь, үхрийн махны үнэ 35.4 хувь өсч, ямааны махны үнэ тогтвортой байлаа.

3-р сарын 31 1 кг хонины мах 2875, үхрийн мах 3250, ямааны мах 1800, шингэн сүү 2000 төгрөгийн үнэтэй байсан байна.



Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр 3.7 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 24.6 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 25.9 тэрбум төгрөгийг буюу 105.3 хувийг эргүүлэн татсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 1099.0 сая төгрөгөөр буюу 42.0 хувиар, гүйлгээнд татсан мөнгө 2.9 тэрбум төгрөгөөр буюу 112.5 хувиар, гүйлгээнд гаргасан мөнгө 3.1 тэрбум төгрөгөөр буюу 14.3 хувиар тус тус өссөн байна.


Зээлийн өрийн үлдэгдэл 26.6 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.4 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 339.3 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар буурч, хугацаа хэтэрсэн зээл өнгөрсөн оны түвшинд байна.

1,0 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.9 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 768.1 сая төгрөгөөр буюу 376 хувиар өссөн байна.


Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 13.1 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.6 хувиар буюу 1.5 тэрбум төгрөгөөр өсөж, харин оны эцэсээс 14.9 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийт зээлийн 5.4 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байгаа бөгөөд Төрийн банкны нийт зээлийн 9.9, ХААН банк 5.2, Хас банкны 1.9, Хадгаламж банкны 28.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.


Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл сая.т.өг



Хадгаламжийн үлдэгдэл сая.т.өг



Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь



Ажилгүйдэл


Хөдөлмөр зохицуулах албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй эрж буй 2223 ажилгүйдчүүд байгаагийн 48.9 хувь нь буюу 1087 эмэгтэйчүүд байна.

Насанд хүрсэн 10.0 мян хүнд 459 ажилгүйдчүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 21.6 хувиар өссөн байна.

Оны эхний 3 сарын байдлаар ажилгүйдчүүдийн тоо сүүлийн 4 жилийн дунджаас 32.7 хувиар өссөн байна.

10000 хүнд ноогдох ажилгүйдчүүдийн тоогоор аймгийн дунджаас Давст 96 пунктээр, Түргэн 234 пунктээр, Улаангом 351 пунктээр илүү бөгөөд бусад бүх сумдууд 54-340 пунктээр бага байна.


Ажилгүйдчүүдийн тоо сүүлийн 5 жилээр




Энэ 3-р сард 127 хүн ажилгүйдчүүдэд нэмж бүртгэгдэн ажилгүй байсан хүмүүсээс 84 хүн ажлын байнгын болон түр байраар хангагджээ.

3-р сард ажилгүйдчүүдэд бүртгүүлэгчдийн 4.7 хувь нь орон тооны цомхтголоос, 3.9 хувь нь байгууллага татан буугдсанаас, 5.5 хувь нь сургууль төгссөн, 84.3 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлсэн, ажилд орогчидын 1.2 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 16.7 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 21.4 хувь нь нөхөрлөл, компанид, 60.7 хувь нь бусад газарт ажилд орсон байна.

ХХҮХ-т шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон хүний тоо, жил бүрийн эхний сараар




Ажилгүйчүүдийн 1.6 хувь нь анх удаа ажил эрж байгаа бөгөөд 48.7 хувь 16-34 насны залуучууд, 19.9 хувь нь дээд, 21.8 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 55.5 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 2.9 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.



Эрүүл мэнд


Энэ оны эхний 1-р улиралд 493 эхээс 495 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 122 оор буюу 19.8 хувиар цөөн байна.

Гэрийн төрөлт 13 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5 төрөлтөөр нэмэгдсэн байна.



Хүн амын нас баралт 151 гарч 1000 хүнд 1.9 ноогдох болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 12.7 хувиар, 1000 хүнд ноогдох нь 0.3 пунктээр нэмэгдсэн байна.


Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 35 гарч 1000 амьд төрөлтөнд 70.7 ноогдож өнгөрсөн оны мөн үеэс гаралт 16-аар буюу 84.2 хувиар, 1000 амьд төрөлтөнд ноогдох нь 39.9 промилиэр нэмэгдсэн байна.





5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Улаангом, Тариалан, Өмнөговь сумдад аймгийн дунджаас 18.1-38.2 промилиэр бага, Бөхмөрөн, Завхан, Зүүнхангай, Сагил сумдад гараагүй, бусад сумдад аймгийн дунджаас 12.6 – 2929.3 промилиэр их байна.

0-1 насны хүүхдийн эндэгдэл 25 гарч нялхсын эндэгдлийн түвшин 50.5 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс гаралт 9-өөр, 1000 амьд

төрөлтөнд ноогдох эндэгдэл 24.6 промилиэр нэмэгджээ.



Нялхсын эндэгдлийн түвшин Улаангом суманд аймгийн дунджаас бага Завхан, Өмнөговь сумдад гараагүй, бусад сумдад 2.1 – 949.5 промилиэр дээгүүр байна. Нийт нас баралтын 21.2 хувийг эмнэлгийн нас баралт, үүний 18.7 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Эхийн эндэгдэл 2 буюу Баруунтуруун, Улаангом сумдад гарч, осол гэмтлийн улмаас 17, хорт хавдрын улмаас 40 хүн нас баржээ.



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 209 болж өнгөрсөн оны мөн үеэс 42.3 хувь буюу 153 гаралтаар буурсан байна.




10000 хүн тутмаас 27 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд энэ үзүүлэлт Улаангом / 61.4 / суманд аймгийн дунджаас дээгүүр, Хяргас, Өндөрхангай, Зүүнхангай, Завхан, Баруунтуруун сумдад гараагүй бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна.


Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 14.4 хувь нь гепатит, 38.8 хувь нь БЗХӨ, 9.1 хувь нь сүрьеэгээр, 3.8 хувь нь мөөгөнцрөөр, 19.5 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2010-3 сар



Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд 2009 - 3 сар



Өнгөрсөн оны мөн үеэс сүрьеэ 4, хүйтэн 30, трихоманиаз 13, гахай хавдар 30 гаралтаар нэмэгдэж, гепатит 54, бруцеллөз 4, мөөгөнцөр 4, тэмбүү 4, салхинцэцэг 138 гаралтаар буурч, гар хөл амны өвчин, суулгалт халдвар, улаанууд, гар хөл амны өвчнүүд гараагүй байна.



Амбулаториор 82.7 мянган хүнд үзлэг хийгдэж, стационариар 5.3 мянган хүн эмчлэгдсэн байна.

Хувийн хэвшлийн 10 эмнэлгүүд 1.5 мянган хүн үзлэг, эмчилгээ, оношлогоо хийж 5.8 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс үйлчлүүлэгчид нь 1.1 мянгаар, орлого нь 9.9 сая төгрөгөөр бага байна.

Нийгмийн даатгал, халамж, нөхөн олговор

НДС- д шимтгэлээр 1174.2 сая төгрөг оруулахаас 1191.2 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 101.5 хувиар биелүүллээ.

Сангуудаар авч үзвэл тэтгэвэрийн даатгалын сангийн орлого 1.9 хувиар, ЭМД-н сангийн орлого 0.03 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 7.2 хувиар, ҮОМШӨ-н сангийн орлого 0.2 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 0.03 хувиар тус тус давж биелэгдсэн байна.

НДС-ийн шимтгэлийн төлөвлөгөөг Баруунтуруун, Улаангом сумдууд 1.7-7.2 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд бусад бүх сумдууд 3.8-14.3 хувиар тасалсан байна.

2.1 тэрбум төгрөг тэтгэвэрт, 344.0 сая төгрөг ЭМД-ын санхүүжилтэнд зориулан зарцуулж тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн санхүүжилтийг бүрэн олголоо. НДС 157.4 сая төгрөгийн авлагатай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 40.1 сая төгрөгөөр буюу 20.3 хувиар буурсан байна.


Тэтгэмжийн даатгалын сангаас 124.8 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 60.0 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 22.4 сая төгрөг, нийтдээ даатгалын сангуудаас 2.7 тэрбум төгрөг зарцуулсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шимтгэлийн орлогын хэмжээ 12.0 хувиар буюу 127.2 сая төгрөгөөр, нийт зарлага, санхүүжилт 3.5 хувиар буюу 92.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.



Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт төрлөөр, эхний 1-р улирлаар, сая төгрөгөөр



Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт төрлөөр, эхний 1-р улирлаар, сая төгрөгөөр



Нийгмийн халамжийн сангаас 57.1 мянган хүнд 3934.5 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлтүүд олгогдсон байна. Эхний I улиралд хүний хөгжил сангаас 42.2 мянган хүүхэд, өндөр настангуудад 2953.0 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж

олгосон байна. Эхний I улиралд 5387 алдарт эхийн одонтой эхчүүдэд 344.3 сая төгрөгийн тусламж олгогдсон байна.

Энэ улиралд 2 хүнд 600.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгож, өнгөрсөн оны мөн үеэс хамрагдсан хүний тоо 2-оор буурсан боловч олгосон нөхөн олговор 277.6 сая төгрөгөөр буюу 86.1 хувиар өссөн байна.


Баруун бүсийн ахмадын асрамжийн үйлчилгээний төвд 1-р улирлын байдлаар нийт 18 хүн асруулж байгаа бөгөөд 61.1 хувь буюу 11 эмэгтэй, 27.3 хувь буюу 3 хүүхэд байна. Нийт асрамжийн үйл ажиллагаанд 37.5 сая төгрөг зарцуулагдсан байгаагын 22.9 сая төгрөг нь эмэгтэйчүүдэд, 6.2 сая төгрөг нь хүүхдүүдэд зориулагдан зарцуулсан байна.

Халамжийн сангийн зарцуулалт бүтцээр, 2010 оны 1-р улирал




Соёл


Аймгийн хөгжимт драмын театр нийт 3.4 мянган хүнд 14 тоглолтоор үйлчилж ажилласан нь өнгөрсөн оноос тоглолтын тоо 56.2 хувиар буурч, орлого 95.2 хувиар тус тус буурч, үзэгчид нь 6.3 хувиар нэмэгдсэн байна.



Орон нутгийг судлах музей 0.9 мянган хүнд үйлчилж 329.6 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс үзэгчид 28.6, орлого 33.1 хувиар нэмэгдсэн байна.



Төв номын сан 0.7 мянган байнгын уншигч, 6.4 мянган ирэгсдэд 7.6 мянган номоор үйлчилж 236.5 мянган төгрөгийн орлоготой ажилласан ба өнгөрсөн оны мөн үеэс уншигчдын тоо 30 хувиар, уншуулсан ном 20.8 хувиар буурч, орлого нь 3.2 дахин нэмэгдсэн байна.



Хөдөө аж ахуй

Том малын зүй бусын хорогдол

Оны эхний малын 14.6 хувь буюу 337.9 мянган толгой мал хорогдсон нь өнгөрсөн оноос 2.9 дахин буюу 221.4 мянган толгойгоор илүү байна.


Нийт хорогдлын 3.5 хувийг өвчний хорогдол эзэлж байна. 86.2 мянган хээлтэгч мал хорогдсон нь

том малын зүй бус хорогдлын 25.5 хувийг эзэлж байна.

Нийт хорогдлын 48.0 хувийг хонь, 47.0 хувийг ямаа, 3.0 хувийг үхэр, 1.9 хувийг адуу, 0.1 хувийг тэмээний хорогдол эзэлж байна.




Нийт хорогдолд эзлэх хувь



Наранбулаг, Завхан, Түргэн, Өлгий, Өндөрхангай, Тариалан, Зүүнхангай, Зүүнговь, Баруунтуруун сумдын оны эхний малын 18.8 – 37.1 хувь нь хорогдож аймгийн дунджаас 4.2 – 22.5 пунктээр их, бусад сумдын оны эхний малын 1.3 – 14.2 хувь хорогдсон нь аймгийн дунджаас 0.4 – 13.3 пунктээр бага байна.

Хамгийн их хорогдолтой Зүүнговь, Зүүнхангай, Өндөрхангай, Наранбулаг, Баруунтуруун, Тариалан, Түргэн, Өмнөговь, Сагил, Өлгий, Завхан зэрэг 11 сумдад аймгийн нийт хорогдлын 79.7 хувийг эзэлж байна.

Манай аймагт 1960 оны зуданд оны эхний малын 11.5 хувь буюу 162.2 мянган толгой мал, 1966 онд оны эхний малын 17.2 хувь буюу 274.1 мянган мал, 2000 онд оны эхний малын 15.2 хувь буюу 286.8 мянган мал тус тус хорогдож байсан байна.




Төллөлт, төл бойжилт

Оны эхний эхийн 29.2 хувь буюу 314.6 мянган эх мал төллөж, гарсан төлийн 60.7 хувь буюу 190.6 мянган төл бойжиж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бойжилтын хувь 18.9 пункт, төллөлтийн хувь 18.7 пунктээр тус тус доогуур, харин төлийн хорогдол 10.4 мянгаар өссөн байна.

Тариалан, Завхан, Өмнөговь, Улаангом, Ховд, Бөхмөрөн, Өлгий, Тэс, Өндөрхангай сумдын төллөх насны эхийн 1.2 – 27.7 хувь нь төллөсөн нь аймгийн дунджаас 1.5 – 20.8 пунктээр бага байна. Нийт 123.9 мянган төл хорогдсоны 99.3 хувийг хурга, ишигний хорогдол эзэлж байна. Малчин, Наранбулаг, Өмнөговь, Өлгий, Өндөрхангай, Зүүнговь, Зүүнхангай сумдууд төлийн хорогдол ихтэй,

гарсан төлийн 14.5 – 57.6 хувийг бойжуулж байгаа нь аймгийн дунджаас 3.1 – 46.2 пунктээр бага байна.



Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

2009 оны 9 дүгээр сараас эхлэн хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн болох 119 нэрийн бүтээгдэхүүний үнийг бүх сумдаас цуглуулан авч аймгийн дундаж үнэ тооцож байна. Бүтээгдэхүүний нэр, төрлийг нилээд задалж ангилсан учир өнгөрсөн жилүүдтэй харьцуулах боломжгүй тул өмнөх сартай харьцуулж танилцууллаа.

Малын үнэ 2010 оны 3-р сарын 28-ны байдлаар аймагт тэмээ зарагдаагүй, харин өсвөр

болон нас гүйцсэн адуу 226.0 – 246.7 мянга, өсвөр насны болон нас гүйцсэн эм ба эр үхэр 166.0 – 290.0 мянга, өсвөр насны төлөг, нас гүйцсэн эр ба эм хонь 23.4 – 53.0 мянга, өсвөр насны борлон, нас гүйцсэн эр ба эм ямаа 13.7 – 32.8 мянган төгрөгний дундаж үнэтэй байна.

Аймгийн дунджаас Цагаанхайрхан, Давст, Түргэн суманд нас гүйцсэн морь, шар, эм үхрийн үнэ 10.0 – 60.0 мянган төгрөг, Тэс, Давст, Өндөрхангай, Түргэн, Наранбулаг суманд нас гүйцсэн эр хонины үнэ 2.0 – 12.0 мянган төгрөг, Түргэн, Өндөрхангай, Цагаанхайрхан, Давст суманд нас гүйцсэн эр ямааны үнэ 2.2 – 7.2 мянган төгрөгөөр тус тус илүү ханштай байна.

3 дугаар сарын 28 - ны байдлаар өсвөр насны ба эм үхэр, эр ба эм ямаа, хонины үнэ өмнөх сартай харьцуулахад 0.7 – 5.7 мянган төгрөгөөр өсч, бүх насны адуу, эр үхрийн үнэ 11.8 – 40.4 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

ХАА - н зарим бүтээгдэхүүн:



Гол нэрийн бүтээгдэхүүн болох ноолуур 38000, үхрийн шир 4750, хонины арьс 500, хонины мах 3000, сүү 2000, ямааны арьс 10500 төгрөгийн дундаж үнэтэй байна.


Мал, амьтны гаралтай зарим түүхий эдийн үнийг өмнөх сартай харьцуулахад хонь ба үхрийн махны үнэ 200 – 1000 төгрөг, ноолуур 6000 төгрөгөөр тус тус өсч, харин хонь ба ямааны арьс, үхрийн ширний үнэ 1.0 – 2.2 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн:

Улаан буудай 600.0 мянга, задгай өвс 45.0 мянга, боодолтой өвс 4375, түлээний мод 22500, сонгино 1500 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад улаан буудай 100.0 мянган төгрөгөөр өсч, боодолтой өвс, сонгино 330 - 500 төгрөг, түлээний мод 1250 төгрөгөөр тус тус буурчээ.






АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 1.1 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 18.1 хувиар буюу 178.4 сая төгрөгөөр өслөө.


Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлт бууралт /сая төгрөг/, 2005 оны зэрэгцүүлэх үнээр



Нийт үйлдвэрлэлтийн 51.8 хувийг хүнс ундааны үйлдвэрлэл, 29.3 хувийг эрчим хүч түгээлт, 11.0

хувийг нүүрс олборлолт, 6.1 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл, 1.2 хувийг усан хангамж, 0.6 хувийг хувцас үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар, 2010 оны 03 сар



Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ нүүрс олборлолт 73.7, бусад боловсруулах үйлдвэрлэл /өлөн, шөвөр, булигар, хөх шир/ 46.8, эрчим хүч түгээлт 15.6, хүнс ундааны үйлдвэрлэл 7.4 хувиар өсч, усан хангамж 5.6, хувцас үйлдвэрлэл 9.8 хувиар тус тус буурсан байна.

Оны үнээр 1.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2.1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс борлуулалтын орлого 30.2 хувиар буурсан байна. Нийт борлуулалтын 5.0 хувь буюу 106.4 сая төгрөгийн боловсруулсан өлөн гэдэс болон нүүрс гадаадад экспортолсон байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх хүнс ундааны үйлдвэрлэлтийн хувь 0.7, хувцас үйлдвэрлэл 0.2, бусад боловсруулах үйлдвэрлэл 0.7 пунктээр өсч, нүүрс олборлолт 0.9, эрчим хүч түгээлт 0.6 пунктээр


буурч, усан хангамж өнгөрсөн оны түвшинд байна.

Салбарын бүтэц

	2008 I-III	2009 I-III	2010 I-III
Цахилгаан дулаан түгээлт	37.7	29.3	28.7
Нүүрс олборлолт	9.5	11.0	10.1
Бусад ашигт малтмал олборлолт	0	0	0
Хүнс ундаа үйлдвэрлэл	46.8	51.8	52.5
Хувцас үйлдвэрлэл	0.3	0.6	0.8
Мод модон бүт үйлдвэрлэл	0	0	0
бусад боловсруулах аж үйлдвэр	4.2	6.1	6.8
Усан хангамж	1.5	1.2	1.2
Дүн	100.0	100.0	100.0

2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор суурь он буюу 2005 оноос боловсруулах үйлдвэрлэл 12.1, уул уурхай олборлолтын салбар 6.6, эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 3.4 дахин өссөн байна.

аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт/2005 I-III =100%/




Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2005 оны мөн үетэй харьцуулбал өлөн 21.8, архи 13.3 ундаа 5.4, нарийн боов 3.5, нүүрс 6.6, дулаан 4.0, түгээсэн цэвэр ус 3.1 дахин өсчээ.


гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт /2005=100%/




Гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2005=100%/



гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2005=100%




2005 оноос импортын цахилгаан 38.1, цахилгааны хэрэглээ 34.6 хувиар өссөн байна.



Тээвэр холбоо

Зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд 8.6 мянган зорчигч тээвэрлэж 2664 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зорчигчдын тоо 46.6, зорчигч эргэлт нь 6.7 хувиар буурсан байна.

Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 24.5 мян.тн ачаа тээвэрлэж 6105.6 мян.тн.км-ийн ачаа эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тээсэн ачаа нь 9.3 ачаа эргэлт нь 9.0 хувиар буурчээ.



2007-2008 онуудад хувийн тээвэр эрхлэгчдийн мэдээллийг оруулж тооцоогүй болно.

Холбооны газар системээрээ 52.3 сая төгрөгийн орлоготой ажилласны 41.1 хувь нь хүн амаас

Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгжүүд 25 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч 9 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны түвшинд 1 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс сироп 5.1, варень 3.0, чацарганы шүүс 2.8 д, хэрчсэн гурил 94.3, нүүрс 73.7, ундаа 72.4, эмэгтэй хос 50.0 хөх шир 50.0, өлөн 45.2, гутал 20.8, дулаан 15.6 хувиар өсч, хүнсний давс 97.6, булигар 50.0, витамин жүүс 44.5, шевро 40.0, чацарганы тос 6.9, дээл 2.1 хувиар тус тус буурсан байна.


	2006 I-III	2007 I-III	2008 I-III	2009 I-III	2010 I-III
нүүрс тн	6.7	5.2	7.8	8.6	12.6
архи мөн л	58.3	112.4	38.4	39.8	82.5
ундаа мөн л	6.3	5.2	3	7.5	15
нарийн боов тн	12	64	45.6	40.8	54.6
өлөн мөн гог	20	6.2	25.2	37.6	30.1

орсон ба өнгөрсөн оны мөн үеэс нийт орлого нь 46.4 хувиар буюу 45.2 сая төгрөгөөр буурчээ.

Холбооны газраар үйлчлүүлсэн цахилгаан мэдээний тоо 50 хувь буурч, бичиг, захидал, боодол хүргүүлэх үйлчилгээ 2.6 дахин өссөн байна.

Аймгийн бүх сумдад үүрэн телефоны операторууд үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдний хэрэглэгчдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 0.3 хувиас 3.2 дахин өссөн байна.

Үүрэн телефон хэрэглэгчдийн тоог харуулбал / тоо/:





Гадаад худалдаа


Оны эхний улиралд 507.9 мянган ам долларын бараа бүтээгдэхүүнийг экспортолж, 5372.8 мянган ам долларын барааг импортолж, өнгөрсөн оны мөн үеэс экспорт 28.5 хувиар, импортын хэмжээ 43.0 хувиар тус тус өссөн байна.

155.7 тн үхрийн мах, 115.9 тн адууны мах, 147 хос гутал, 10 ширхэг хивс, 245 ширхэг хүрэм, 130 ширхэг өмд, 55 ширхэг хөнжил, 54 ширхэг цахилгаан тогоо экспортолж, 774 тн гурил,

2776.4 тн бензин, 2524.6 тн дизель түлш, 14281.6 мян.квт.цаг цахилгаан, 543 тн хивэг, 12 тн хөц будаа, 151.5 тн хорголжин тэжээл, 174 ширхэг мебель тавилга, 1.9 тн хүнсний бараа, 4 ширхэг шингэний нөөцлүүр зэрэг бараа бүтээгдэхүүнийг импортоор авсан байна.

Өнгөрсөн оны мөн үеэс экспортолсон үхрийн махны хэмжээ 116.2 тн-оо буюу 3.9 дахин өссөн бөгөөд харин адууны махны хэмжээ 117.1 тн-оор буюу 50.3 хувиар буурсан бөгөөд импортоор авсан гурил 41.2 хувиар, дизель түлш 13.1 хувиар, цахилгаан 23.8 хувиар, хөц будаа 20.0 хувиар тус тус буурсан байна. Харин өнгөрсөн оны мөн үетэй харицуулахад 151.5 тн овъёс, 64 тн хорголжин тэжээл, 174 ш мебель тавилга, 1.9 тн хүнсний бараа, 4 ширхэг шингэний нөөцлүүр нэмэгдэж, авто бензин 2.3 дахин, хивэг 3.7 дахин тус тус өссөн байна.






Гэмт хэрэг

Оны эхний 3 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 93 болж өнгөрсөн оны мөн үеэс 5.7 хувиар, сүүлийн 4 жилийн дунджаас 10.1 хувиар тус тус өсч, гэмт хэрэгт холбогдогч 89 болж өнгөрсөн оны мөн үеэс 4.7 хувиар өссөн байна.

Бүрт гэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 3 сараар



Гэмт хэрэгт холбогдогчдоос 3.4 хувь буюу 3 эмэгтэй, мөн 1.1 хувь буюу 1 хүүхэд байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хэрэгт холбогдогч эмэгтэйчүүдийн тоо 40.0 хувиар, хүүхдүүдийн тоо 75.0 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэд байгууллагад 72.6 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 14.6 хувиар буурсан байна. Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн

18.4 хувь нь бүлэглэж үйлдсэн, 24.5 хувь нь согтуугаар үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүлэглэсэн хэрэг 7.7 пунктээр буурч, харин согтуугаар үйлдсэн хэрэг 10.9 пунктээр буюу гаралтын тоо 2.0 дахин өссөн байна.

Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 12.9 хувиар, үүний дотроос иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэрэг 19.2 хувиар тус тус буурч, харин бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 50.0 хувиар өссөн байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 19.1 хувиар, үүний дотроос нийт хулгайн гэмт хэрэг 30.8 хувиар буурсны дотор иргэдийн өмчийн хулгайн хэрэг 33.3 хувиар, малын хулгай 29.6 хувиар, мөн бусад хулгайн гэмт хэрэг 25.0 хувиар тус тус буурсан бөгөөд завшин үрэгдүүлэх гэмт хэрэг 33.3 хувиар өссөн байна.

Тээврийн хэрэгслэлийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг хэрэг 2 дахин, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 5 дахин, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 дахин өссөн бөгөөд өнгөрсөн оны 3 сард гарч байгаагүй хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг хэрэг, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг, залилангийн хэрэг, аж ахуйн нэгжийн эсрэг хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд 1-4 тохиолдол гарсан байна.

ЦАГ УУРЫН БАЙДАЛ

2010 оны 3-р сард агаарын дундаж температур Улаангом, Баруунтуруун, Давст, Зүүнговь, Тэс, Малчин -19.2-ээс -22.8 хэм хүйтэн, хөрсний дундаж температур Зүүнговь, Малчин, Тэс, Түргэн, Сагил сумдад -19.0 ээс -23.1 хэм хүйтэн байлаа.

10 м/сек –ээс их салхитай өдөр Өмнөговьд 15, Завханд 11, Зүүнговьд 11, Зүүнхангайд 24, Наранбулагт 17 хоног байв.

Баруунтуруунд 11, Хяргаст 9, Малчинд 4, Тэсд 9, Зүүнхангайд 8, Сагилд 8 хоног тундастай байж нийлбэрээрээ Баруунтуруунд 11.5 мм, Давстад 9.4 мм, Хяргаст 8.5 мм, Тэсд 9.8 мм цас орсон нь аймгийн хэмжээнд хамгийн их тундастай сумдууд болж байна.

Цасны зузаан Баруунтуруун 26 см, Малчин 22 см, Давст 22 см, Зүүнговь 25 см, Тэс 25 см, Хяргас 28 см, Сагил 22 см, Түргэн 16 см байгаа нь бусад сумдаас харьцангуй илүү байна.

АЙМГИЙН

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ЭРДЭНЭСҮРЭН



Нийт гэмт хэргийн 45.2 хувь нь Улаангом суманд үйлдэгдсэн ба үйлдэгдсэн нийт хэргийн дийлэнх хувийг / 29.0 / нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Насанд хүрсэн 10.0 мянган хүнд ноогдох 21 гэмт хэрэг ноогдож байгаа бөгөөд Баруунтуруун, Давст, Малчин, Саил, Түргэн, Тэс, Ховд, Улаангом сумуудын гэмт хэргийн гаралт аймгийн дунджаас 1.0-15.0 пунктээр илүү бөгөөд бусад сумдад аймгийн дунджаас 1.0 –15.0 пунктээр бага байна.

Шүүхээр 30 гэмт хэрэгт 47 хүн ял шийтгүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс шийдүүлсэн гэмт хэрэг 48.3 хувиар, шийтгүүлсэн хүний тоо 54.8 хувиар тус тус буурсан байна.

